



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар сарын  
21-ний өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 193

#### **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа Монгол Улсын төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны үнэлгээний жишигт нийцүүлэн үнэлүүлж санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

3. Концессын гэрээний дагуу барьж байгуулсан барилга, зам, гүүрийн байгууламж, тоног төхөөрөмж болон бусад концессын зүйлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, төрийн өмчийн бүртгэлд тусгах асуудлыг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлж байхыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасугай.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр барьж байгуулсан барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин техник зэрэг хөрөнгийг орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх болон тухайн хөрөнгийг төрийн байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж

2017 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

6. Төрийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх, татан буулгах үйл ажиллагааг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэн хамтран зохион байгуулж, өмчийн бүртгэлд тусгуулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

7. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран авч хэрэгжүүлэн, нэгдсэн дүнг 2017 онд багтаан Засгийн газарт оруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

8. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор илэрсэн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах, дуусаагүй барилга байгууламжийг судлан хууль тогтоомжийн дагуу зохих шийдвэр гаргахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ